



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/08

Чингис хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн орон сууцны корпораци нэхэмжлэл гаргасантай холбогдуулж Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/ Хариуцагч Аймгийн Засаг даргын Тамгын газрын итгэмжилсэн төлөөлөгчөөр (хэрэг хянан шийдвэрлэх хугацаагаар) томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/ нарт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйл 26 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР